

# **АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД ГҮЙЦЭТГЭСЭН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ЗАРДЛЫН ДООД ХЭМЖЭЭГ БАТАЛГААЖУУЛАХ ЗААВАР**

## **Нэг. Нийтлэг зүйл**

1.1 Төрийн захиргааны байгууллагаас ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хайгуулын ажилд зарцуулсан зардлын доод хэмжээг хянах, баталгаажуулахад энэхүү зааврын зорилго оршино.

1.2 Геологи, хайгуулын ажлын зардалд геологийн судалгааны бэлтгэл ажил, геологийн зураглал, эрлийн маршрут, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгаа, уул өрмийн ажил, сорьцлолт, лаборторийн шинжилгээ, хүн ба ачаа тээвэр, суурин боловсруулалт, эрэл хайгуулын ажилтай шууд холбоотой томилолт болон хайгуулын ажлын бусад зардлууд хамаарна.

1.3 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид СТОУС-6 гэнэ)-ын дагуу “Ашигт малтмалын хайгуул ба үнэлгээ” аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бодлого зохицуулалтын баримт бичгийг мөрдлөг болгон тусгай зөвшөөрөл бүхий талбайд гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын зардлыг тайлагнана.

1.4 Хайгуулын ажлыг эдийн засгийн хувьд үр өгөөжтэй гэж үзвэл хөрөнгийн дансанд капиталжуулан бүртгэх, үр өгөөж муутай гэж үзвэл тайлант үеийн зардал буюу орлогын тайлангийн “бусад” хэсэгт бүртгэх ба энэ тухай тусгай зөвшөөрөл эзэмшигч санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт тодорхой бичиж тайлагнана.

1.5 Тусгай зөвшөөрлийг эзэмшихтэй холбогдон гарсан зардлууд (үйлчилгээний хөлс, тусгай зөвшөөрлийн төлбөр г.м), тусгай зөвшөөрлийн талаарх мэдээ, мэдээлэл худалдаж авсан үнийн дүнг “Биет бус хөрөнгө” –ийн дансанд тайлагнана. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлд ААНБОАТ-ын хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 –т зааснаар хүчин төгөлдөр байх хугацаанд нь элэгдэл тооцож үнийн дүнг хорогдуулна.

1.6 “Хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын “Хөрөнгийн эх үүсвэрийн мэдээ” –г маягт 9-ийн дагуу гаргаж, хайгуулын ажлын тайлангийн хамт жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

1.7 “Хайгуулын ажлын зардлыг бүртгэсэн дансны тодруулга “-г маягт 10-ын дагуу гаргаж жилийн тайлан тэнцлийн хамт ирүүлнэ.

1.8 Санхүүгийн тайлан тэнцлийг харьяа санхүүгийн болон татварын хэлтсээр хянуулж баталгаажуулсан байх шаардлагатай.

## **Хоёр. Хайгуулын ажлын зардлын доод хэмжээг баталгаажуулах**

2.1 Хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд явуулсан геологи хайгуулын ажлын жилийн тайлан болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүүгийн тайлан тэнцэлд тулгуурлан баталгаажуулна.

2.2 Тусгай зөвшөөрлийн тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлаар хайгуулын ажлын зардлын хэмжээг тодорхойлно.

2.3 Хайгуулын ажлын зардлын доод хэмжээг баталгаажуулахдаа тусгай зөвшөөрөл олгогдсон он, сар, өдрөөс эхлэн Иргэний хуулийн 72, 73-р зүйлүүдэд заасан “хугацаа тоолох журмын дагуу” тооцож дараа жилийн он сар өдрөөр тооцож баталгаажуулна.

2.4 Хайгуулын ажлын доод хэмжээ баталгаажуулах эрх, үүрэг тусгай зөвшөөрлийн 2 дахь жилээс эхлэн үүснэ.

2.5 Тухайн жилд гүйцэтгэсэн хайгуулын ажлын доод хэмжээг баталгаажуулах хугацаа дараа жилийн 2 дугаар улирлын сүүлийн ажлын өдрөөр дуусгавар болно.

2.6 Хайгуулын ажлын зардлын доод хэмжээг баталгаажуулсан тухай тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн тухайн жилийн санхүүгийн тайлан тэнцэлд дардас дарж тэмдэглэнэ.

### **Гурав. Хариуцлага**

3.1 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэхүү зааврын 2.5 дахь хэсэгт заасан хугацааг хожимдуулсан буюу тайлан ирүүлээгүй тохиолдолд Ашигт малтмалын тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэж, “ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 14-р зүйлд заасныг үндэслэн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авна.

-----o o-----

Аж ахуйн нэгжийн нэр

**Хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгийн эх үүсвэрийн мэдээ**

д/д	Үзүүлэлт	Геологийн судалгааны ажил явуулсан эх үүсвэр				
		Гадаадын хөрөнгө	Дотоодын хөрөнгө	Өөрийн	Зээлээр	Гэрээгээр
1	Хөрөнгө оруулагчийн нэр, хаяг, иргэний					
2	Хөрөнгө оруулалтын хэмжээ					
3						
4	Бусад					

Тусгай зөвшөөрөл эзэмшигч .....ХХК-ийн

Тамга

Захирал .....

Ерөнхий нягтлан бодогч .....

**Хайгуулын ажлын зардлын дүнгийн задаргаа**

Дансны нэр:.....

Тусгай зөвшөөрлийн дугаарууд: .....

д/д	Тусгай зөвшөөрлийн дугаар	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Хайгуулын зардал				
2	Лицензийн төлбөр				
3	Лиценз худалдаж авсан үнэ болон үйлчилгээний хөлс				
4	Бусад зардал /эмнэлгийн, зөвлөх, шүүмж гэх мэт/				
5	Лицензтэй холбоогүй зардлууд				
	Нийт дүн				

Тусгай зөвшөөрөл эзэмшигч .....

ХХК-ийн :

Захирал .....

Ерөнхий нягтлан бодогч .....

Хүлээн авсан :

АМГ-ын мэргэжилтэн .....